



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 06 сарын 17-ны
өдрийн 6868 дугаарт бүртгэв.

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.10 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Журам, маягт, загвар батлах тухай" А/45 дугаар тушаал болон 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн "Заавар, аргачлал батлах тухай" А/55 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг Санхүү-нийцлийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор /Я.Самбууням/-т үүрэг болгосугай.

Д.ЗАГДЖАВ

Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн
А/ХТ дугаар тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ БАЙГАА
НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН
ТАЙЛАН ГАРГАХ, ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ, ХЯНАХ,
ДҮНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго

- 1.1. Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан талаар тайлагнах, түүнд дүгнэлт гаргах, сонгуулийн санхүүжилтийг, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Журмын үйлчлэх хүрээ

- 2.1. Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийн хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлан гаргах, сонгуулийн зардлын тайланд аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Үндэсний аудитын газраас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрдөнө.
- 2.2. Энэхүү журам нь “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал” болон тус журмын 17.1-д заасан маягт, 22.7-д заасан дүгнэлтийн загвар бүхий хавсралтаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

Гурав. Сонгуулийн зардлын данс

- 3.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /цаашид “МУИХСтХ” гэх/ 51.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.
- 3.2. Эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэрээр эвсэлд нэгдсэн нэг нам эвслийг төлөөлж эвслийн сонгуулийн зардлын данс нээлгэх ба эвслийг төлөөлөх байгууллагаас эрх олгогдсон этгээд эвслийн сонгуулийн зардлын данснаас зарлага гаргана.
- 3.3. МУИХСтХ-ийн 51.2-т зааснаар нам аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбартай бол тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт сонгуулийн зардлын данстай байж болно.
- 3.4. Нам, эвсэл, нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарснаас хойш нам, эвсэл, нэр дэвшигч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэж сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, бүртгүүлнэ.

Дөрөв. Сонгуулийн зардлын санхүүжилт

- 4.1. Нам, эвслийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.
- 4.2. Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.
- 4.3. Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

Тав. Сонгуулийн зардлыг санхүүжүүлэх намын өөрийн хөрөнгө

- 5.1. Сонгуулийн зардлыг санхүүжүүлэх намын өөрийн хөрөнгө нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын өөрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө байна.
- 5.2. Нам энэ журмын 5.1-д заасан хөрөнгийг өөрийн данснаасаа нам, эвслийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэн зарцуулах ба намын хувьд энэ журмын 3.3-т заасан сонгуулийн зардлын данс нээлгэсэн тохиолдолд уг дансаар дамжуулан зарцуулж болно.
- 5.3. Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.
- 5.4. Нам, эвсэл сонгуулийн зардлыг санхүүжүүлэх намын өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Зургаа. Сонгуулийн зардлыг санхүүжүүлэх нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө

- 6.1. Сонгуулийн зардлыг санхүүжүүлэх нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.
- 6.2. Нэр дэвшигч энэ журмын 6.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандаа байршуулж зарцуулна.
- 6.3. Нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Долоо. Сонгуулийн хандив

- 7.1. МУИХСтХ-ийн 53.1-д зааснаар сонгуулийн хандив нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.
- 7.2. Хандив нь хандивлагчийн өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын чадамжаас даваагүй, бодитой байна.
- 7.3. Хандивлагч нэг нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгсөн нь өөр нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- 7.4. Хандивлагч нэр дэвшигчид мөнгөн хандив өгсөн нь тухайн нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.5. МУИХСтХ-ийн 56.1-д заасан этгээд хандив өгөхийг хориглох ба нам, эвсэл, нэр дэвшигч шаардсан тохиолдолд хандивлагч нь уг шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

Найм. Мөнгөн хандив

8.1. Хандивлагч этгээдээс эргэж төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

8.2. МУИХСтХ-ийн 54.1-д заасны дагуу мөнгөн хандив нь иргэний хувьд 10,000,000 (арван сая) төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 30,000,000 (гучин сая) төгрөг хүртэл байна.

8.3. Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

8.4. Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

Ес. Мөнгөн бус хандив

9.1. Хандивлагч этгээд сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

9.2. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх мөнгөн бус хандивын гэрээг тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.3. Үйлчилгээ үзүүлэх мөнгөн бус хандивыг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.4. МУИХСтХ-ийн 56.5-д заасны дагуу нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

Арав. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох

10.1. Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах байдлаар тодорхойлно:

10.1.1. тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

10.1.2. тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнийн дундаж үнэлгээгээр.

10.2. Мөнгөн бус хандивын үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгч болох мөнгөн хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

Арван нэг. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

11.1. Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно

- 11.1.1. банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, хуулийн этгээдийн хувьд байгууллагын регистрийн дугаар, иргэний хувьд иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;
- 11.1.2. буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;
- 11.1.3. МУИХСтХ-ийн 56.1-д хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;
- 11.1.4. хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

11.2. Нам, эвсэл, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

Тайлбар: Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив гэдэгт хандивлагчийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, байгууллагын регистрийн дугаар банкны дансны дугаар зэрэг мэдээлэл зөрүүтэй байхыг хамруулж ойлгоно.

Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын орлогод шилжүүлэх

12.1. Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын орлого болгоно:

- 12.1.1. энэ журмын 11.1.1, 11.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;
- 12.1.2. энэ журмын 12.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 11.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын орлого болгох;
- 12.1.3. энэ журмын 11.1.4-т заасан хандивыг улсын орлого болгох.

12.2. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1.2, 12.1.3-д заасны дагуу улсын орлого болгох хандивыг улсын төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох

13.1. Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансанд хүлээн авснаас хойших сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь уг мөнгөн хандивын хэмжээнээс бага байж болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Арван дөрөв. Сонгуулийн зардлын ангилал

14.1. Сонгуулийн зардлыг нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалд заасан үзүүлэлтийг харгалзан ангилна.

14.2. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлагнана:

- 14.2.1. сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал;

- 14.2.2. нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал;
- 14.2.3. намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал;
- 14.2.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал;
- 14.2.5. сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:
- а. нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;
 - б. нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал;
 - в. нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал;
 - г. нам, эвслээс зарцуулах томилолтын зардал;
 - д. сонгуулийн үйл ажиллагааны бусад зардал.
- 14.2.6. сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал;
- 14.2.7. сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал;
- 14.2.8. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал;
- 14.2.9. бусад зардал.

Арван тав. Сонгуулийн зардал гаргах

- 15.1. Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах хүртэл хугацаанд энэ журмын 14.2-т заасан сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.
- 15.2. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данснаас гаргасан зарлага тус бүрийн зориулалт нь хүчин төгөлдөр анхан шатны баримтаар нотлогдсон байна.
- 15.3. Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.
- 15.4. Дараах зардлын нийт дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй:
- 15.4.1 сонгуулийн зардлын данснаас зарлага болгосон энэ журмын 14.2-т заасан зардлын дүн;
 - 15.4.2 сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөрийн дүн;
 - 15.4.3 мөнгөн бус хандивын хэмжээ (энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна).
- 15.5. Энэ журмын 15.4-т заасан зардлын дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг нам, эвсэл, нэр дэвшигч улсын орлого болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Арван зургаа. Сонгуулийн зардлын тайлан

- 16.1. Сонгуулийн зардлын тайланг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилна.

- 16.2. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлан гаргана.
- 16.3. Сонгуулийн зардлын тайланд нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

Арван долоо. Сонгуулийн зардлын явцын тайлан гаргах

- 17.1. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан тус журмын хавсралт 2 “нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах Маягт (1-ээс 9)”-ын дагуу гаргаж, Үндэсний аудитын газарт ирүүлнэ.
- 17.2. Нийслэлээс бусад тойрогт нэр дэвшигч энэ журмын 18.1-д заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайлангийн эх хувийг ирүүлэх боломжгүй тохиолдолд цахим хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим шууданд илгээж, эх хувийг санал авах өдрөөс 1 хоногийн өмнө Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.
- 17.3. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын явцын тайланд данс нээлгэсэн өдрөөс сонгуулийн зардлын явцын тайлан гаргах хүртэлх хугацааны сонгуулийн зардлын дансны хуулгыг хавсаргана.

Арван найм. Сонгуулийн зардлын явцын тайланг нийтэд мэдээлэх

- 18.1. Нам, эвсэл, нэр дэвшигч нь МУИХСтХ-ийн 58.4-т заасны дагуу сонгуулийн зардлын явцын тайланг санал авах өдрөөс хойш 3 хоногийн өмнө дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:
- 18.1.1. МУИХСтХ-ийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудаст байршуулах;
 - 18.1.2. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд байршуулах;
 - 18.1.3. мэдээллийн сайт болон бусад олон нийтийн сүлжээнд байршуулах.
- 18.2. Үндэсний аудитын газар нам, эвсэл болон нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн зардлын явцын тайланг хүлээн авмагц өөрийн цахим хуудаст байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайланг ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

Арван ес. Сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах

- 19.1. МУИХСтХ-ийн 57.3-т заасны дагуу нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын эцсийн тайланг гаргаж, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Үндэсний аудитын газарт ирүүлнэ.
- 19.2. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 19.1-д заасны дагуу Үндэсний аудитын газарт ирүүлэх сонгуулийн зардлын эцсийн тайландаа дараах баримт бичгүүдийг хавсаргасан байна.
- 19.2.1 сонгуулийн зардлын дансны хуулга;
 - 19.2.2 сонгуулийн зардлын тайланд тусгасан орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт;
 - 19.2.3 байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

19.2.4 нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг тодорхойлсон нотлох баримт.

Хорь. Сонгуулийн зардлын эцсийн тайланг нийтэд мэдээлэх

20.1. Нам, эвсэл, нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын эцсийн тайланг энэ журмын 18.1-д заасан хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

20.2. Үндэсний аудитын газар энэ журмын 20.1-д заасны дагуу ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын эцсийн тайланг цахим хуудастаа байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын эцсийн тайланг ирүүлээгүй нам, эвсэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

Хорин нэг. Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянах, дүнг мэдээлэх

21.1. Үндэсний аудитын газар энэ журмын 19.1-д заасны дагуу ирүүлсэн сонгуулийн зардлын эцсийн тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.

21.2. Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянахдаа МУИХСтХ-ийн 58.2.2-оос 58.2.4-т заасан болон Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

21.3. Үндэсний аудитын газар энэ журмын 21.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч, бусад иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

21.4. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1, 15.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоогүй зөрчлийн талаар аудитын хуулийн этгээдийн ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн Үндэсний аудитын газар холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

Хорин хоёр. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд дүгнэлт гаргах

22.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

22.2. Сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд нь энэ журмын 22.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл, тайлбараа гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор Үндэсний аудитын газарт мэдэгдэнэ.

22.3. Аудитын хуулийн этгээд энэ журмын 22.2-т заасны дагуу гэрээ байгуулснаас хойш аливаа шалтгаанаар сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийгээгүй, аудит хийхээс татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдэл, тайлбараа 2 хоногийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

22.4. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд хийх аудитыг тухайн

нам, эвсэл, нэр дэвшигчээс энэ журмын 17.1-д заасан маягтын дагуу гаргасан тайлан, энэ журмын 19.2-т заасан баримт бичиг болон анхан шатны баримтад үндэслэн хийнэ.

22.5. Холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч нь аудитын хуулийн этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, эсхүл гуравдагч этгээдээс гаргуулж өгөх, аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй.

22.6. Аудитын хуулийн этгээд дараах асуудлын хүрээнд сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргана.

22.6.1. сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

22.6.2. сонгуулийн зардалд зарцуулсан намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

22.6.3. хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

22.6.4. хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

22.6.5. сонгуулийн зардлын тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

22.6.6. сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайланд үнэн зөв тусгагдсан эсэх.

22.7. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт 800 "Тусгай зорилгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит"-г удирдлага болгон "Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан тус журмын гуравдугаар хавсралт"-ын загварын дагуу дүгнэлт гаргана.

22.8. Аудитын хуулийн этгээд аудитын явц үр дүн болон энэ журмын 22.7-д заасан дүгнэлтэд дэмжлэг болгох зорилгоор дараах бүтэц, агуулга бүхий аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлнэ:

22.8.1. аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

22.8.2. аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт;

22.8.3. тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал;

22.8.4. материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар;

22.8.5. аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн;

22.8.6. илрүүлсэн зүйлсийн нэгтгэл, тайлбар (аудитаар нам, эвсэл, нэр дэвшигч нь энэ журмын 12.1, 15.5-д заасан дагуу улсын орлого болгоогүй зөрчил илэрсэн тохиолдолд Үндэсний аудитын газарт холбогдох нотлох баримтыг хүргүүлж, шийдвэрлүүлэх талаар тусгана.);

22.8.7. санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл;

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ

Хорин гурав. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо


23.1. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллага

дараах оролцоотой байна.

- 23.1.1. сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;
- 23.1.2. сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;
- 23.1.3. нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

Хорин дөрөв. Хариуцлага

- 24.1. Үндэсний аудитын газар нь сонгуулийн зардлын тайлангийн аудитын дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргаагүй, илт худал дүгнэлт гаргасан, эсхүл хуульд заасныг зөрчиж аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
- 24.2. Үндэсний аудитын газар сонгуулийн зардлын тайлантай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан нь илэрсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг нотлох баримт болон бусад холбогдох баримт материалын хамт эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулна.
- 24.3. Үндэсний аудитын газрын хийсэн аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар зохицуулна.



СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ТАЙЛАГНАХ ЗААВАР, АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

Заавар, аргачлал боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан тодорхойлж, сонгуулийн зардлын тайлан гаргах бодлого, аргачлалыг энэ заавраар баталгаажуулав.

Зааврын зорилго, хамрах хүрээ

1.2. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн бодит байдлаар гаргахад энэ заавар, аргачлалын зорилго оршино.

1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон энэ заавар, аргачлалын 1.1-д заасан журмын дагуу сонгуулийн зардлын тайлан гаргах нам, эвсэл, нэр дэвшигч энэхүү заавар, аргачлалыг дагаж мөрдөнө.

1.4. Сонгуулийн зардлын тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээд энэ заавар, аргачлалыг шалгуур үзүүлэлт болгоно.

Батлагдсан маягтын талаарх ерөнхий мэдээлэл

1.5. Сонгуулийн зардлын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны A/44 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-д заасан маягтаар гаргаж баталгаажуулна.

1.6. “Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын хоёрдугаар хавсралтад заасан маягт тус бүрийн талаарх мэдээллийг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

1.6.1. Намын сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-1**), Эвслийн сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-2**), Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн хураангуй (**Маягт 1-3**) хамаарна.

Тодруулга: Эдгээр маягтууд нь нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх ерөнхий мэдээлэл, дансны мэдээллээс гадна сонгуулийн зардлын дансаар орсон, гарсан бүх гүйлгээг ангилан нэгтгэх, сонгуулийн зардлын тайлангийн талаарх мэдээллийг нэгтгэж, баталгаажуулах зорилготой.

Сонгуулийн зардлын тайлангийн хураангуй нь сонгуулийн санал авах өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан болон сонгуулийн дараах

эцсийн тайлан гэсэн 2 төрөлтэй бөгөөд тайланг хэзээ бэлтгэж, баталгаажуулснаас хамаарч тохирох сонголтыг хийнэ.

Нам, эвсэл, нэр дэвшигч өөрт хамаарах тайлангийн маягтыг сонгож, хураангуй тайлан бэлтгэж баталгаажуулна.

1.6.2. Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн тайлан **(Маягт 2):**

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгож баримтжуулах зорилготой.

1.6.3. Мөнгөн хандивын тайлан **(Маягт 3)**, Мөнгөн бус хандивын тайлан **(Маягт 4):**

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчид өгсөн хандивын талаар мэдээллийг нэгтгэж баримтжуулах зорилготой бөгөөд хандивлагчийг иргэн, хуулийн этгээдээр ангилан, хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллийг цуглуулна.

1.6.4. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын тайлан **(Маягт 5);**

Тодруулга: Энэ маягтаар хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивын талаарх мэдээллийг цуглуулахаас гадна хуулиар зөвшөөрөгдөөгүй гэж үзсэн үндэслэл тайлбарыг дэлгэрэнгүй авч, баталгаажуулахаар тооцсон.

1.6.5. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаасан буюу улсын орлого болгосон тухай тайлан **(Маягт 6):**

Тодруулга: Хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандивыг улсын орлого болгосон бол энэ талаарх мэдээллийг цуглуулж, баримтжуулах зорилготой.

1.6.6. Сонгуулийн зардалтай холбоотой өглөгийн тайлан **(Маягт 7):**

Тодруулга: Сонгуулийн зардлын тайланг тайлагнах хугацаанаас хойш хийгдээгүй өр төлбөрийг зардлын зориулалт болон өр үүссэн шалтгаан тайлбартайгаар авч, баталгаажуулах зорилгоор энэ маягтыг боловсруулсан.

1.6.7. Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан **(Маягт 8)**, Сонгуулийн зардлын дансны гүйлгээ тус бүрээр хийсэн зарлагын дэлгэрэнгүй тайлан **(Маягт 9):**

Тодруулга: Тус 2 маягтаар төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын бүх гүйлгээг орлого, зарлагын ангиллаар задалж баталгаажуулахаас гадна дараагийн шатны дэлгэрэнгүй тайлан бэлтгэх үндэслэл болно. Энэ маягтаар бүртгэсэн орлого, зарлагын гүйлгээний нийт дүн нь харилцах дансны хуулгаар гарсан орлого, зарлагын нийт дүнтэй тэнцүү байна.

Хоёр. Сонгуулийн зардлын тайлангийн орлого, зарлагын ангилал

2.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн орлого,

зарлагыг энэ заавар, аргачлалын 1.5-д заасан журмын “зардлын тайлангийн хураангуй маягт”- аар¹ ангилан нэгтгэж, тайлагнана.

Орлогыг ангилах, бүртгэх

2.2. Намын сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ. Орлогын ангилал тус бүрд хамаарах орлогыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

- 2.2.1. Намын өөрийн хөрөнгө;
- 2.2.2. Хуулийн этгээдийн хандив;
- 2.2.3. Иргэний хандив.

2.3. Эвслийн сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ Орлогын ангилал тус бүрд хамаарах орлого болон анхаарах асуудлыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

- 2.3.1. Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө;
- 2.3.2. Хуулийн этгээдийн хандив;
- 2.3.3. Иргэний хандив.

2.4. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангийн орлогын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ.

- 2.4.1. Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө;
- 2.4.2. Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө;
- 2.4.3. Хуулийн этгээдээс өгсөн нийт хандив. Үүнд:

- а.Мөнгөн хандив
- б.Мөнгөн бус хандив

2.4.4. Иргэнээс өгсөн нийт хандив. Үүнд:

- а.Мөнгөн хандив
- б.Мөнгөн бус хандив

Тодруулга: Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны нийт орлогын гүйлгээг **Маягт 8-д** гүйлгээ тус бүрээр оруулах бөгөөд орлогын гүйлгээний дүнг орлогын дээрх ангилалд харгалзуулан хуваарилна. Ингэхдээ нэг гүйлгээний дүн 1-ээс дээш орлогын ангилалд хамаарч байгаа нь анхан шатны баримтаар нотлогдож байвал тохирох орлогын ангилалд салгаж оруулна.

Зарлагыг ангилах, бүртгэх

2.5. Намын сонгуулийн зардлын тайлангийн зарлагын дүнг дараах байдлаар ангилж, нэгтгэнэ. Зарлагын ангилал тус бүрд хамаарах зардал болон анхаарах асуудлыг дараах заалтад үзүүлэв. Үүнд:

2.5.1. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал:

- сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэхтэй холбоотой зардал;

¹Маягт 1-1, Маягт 1-2, Маягт 1-3

- сонгуулийн сурталчилгааны материал тараахтай холбоотой зардал.

2.5.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал:

- зурагт самбар хэвлүүлэхтэй холбоотой зардал;
- зурагт самбарыг байрлуулах хөл, суурь, тогтоогч зэргийг түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал;
- дэлгэц түрээслэх, худалдаж авахтай холбоотой зардал.

2.5.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал:

- намын далбаа, уриа, таних тэмдэг бүхий хуудас хэвлүүлэх болон хувцас бусад бүтээгдэхүүн хийлгэхтэй холбоотой зардал.

2.5.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал:

- Нэр дэвшигчээс болон нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очиж /тойрон аялал/ сонгогчидтой хийсэн уулзалт, хурал, цуглааны үйл ажиллагаанд зориулан гаргасан сонгогчдод харилцаа холбооны болон бусад хэлбэрээр зар хүргэх, урилга хэвлүүлэх, заал, танхим, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, бусад тоног, төхөөрөмж хөлслөх, худалдаж авахтай холбоотой зардлууд;
- Уулзалт, хурал, цуглаан хийхтэй холбоотой хоол, ундны зардал

Анхаарах: Гүйлгээний утга хэсэг дээр хэзээ, хаана болсон уулзалт, хурал, цуглааны талаар тодорхой бичнэ.

2.5.5. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:

- Нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;
- Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал:
 - нам, эвслээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтанд олгосон хөлс, урамшуулал;
 - нэр дэвшигчээс менежер, шадар ухуулах, ухуулагч, ажиглагчид олгосон хөлс, урамшуулал.
- Нам, эвсэл, нэр дэвшигчээс тээврийн хэрэгслийн зардал
 - нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны зориулалтаар ашигласан тээврийн хэрэгсэлд зарцуулсан шатахууны зардал;
 - нам, эвслийн удирдлагаас сонгуулийн тойрогт очих /тойрон аялал/- д гаргасан шатахууны зардал;
 - нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслах, ухуулагчид олгосон шатахууны зардал;
 - Тээврийн хэрэгслийн түрээсийн зардал.
- Нам, эвслээс зарцуулах томилолтын зардал:
 - Нам, эвслийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах /улсын хэмжээнд ажиллах/эрх бүхий ажилтанд олгосон томилолтын зардал.

- Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны бусад зардал:
 - хүнсний, ахуйн хэрэглээний болон бусад хэрэгцээт бараа, материал, тоног төхөөрөмж худалдаж авсан зардал;
 - сонгууль эрхэлсэн байгууллага, түүний бүрэлдэхүүний ажлын хэрэгцээнд ашиглахаар эд хөрөнгө /зочид буудал, гэр гэх мэт/-ийн түрээсийн зардал;
 - бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр;
 - бичиг хэрэг, шуудан, харилцаа холбоо, интернэтийн төлбөр гэх мэт зардал;
 - Сонгууль эрхэлсэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж гаргасан бусад зардал.

2.5.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах:

- Радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк бэлтгэхтэй холбоотой зардал;
- Сонгуулийн сурталчилгааны контент, шторкийг радио, телевизээр нэвтрүүлэхтэй холбоотой зардал.

2.5.7. Цахим орчин ашиглах зардал:

- Домэйн нэр худалдаж авах, хостингийн төлбөр төлөх, цахим хуудас бүтээх, цахим хуудасны хөгжүүлэлтийн зардал;
- Цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн болон бусад цахим хуудсаар дамжуулах сонгуулийн сурталчилгааны контент, шторк, бусад сурталчилгааны мэдээлэл бэлтгэхтэй холбоотой зардал;
- Контент, шторк, бусад сурталчилгааны мэдээллийг цахим орчин дахь олон нийтийн сүлжээ болон бусад цахим хуудсаар нийтэд түгээхтэй холбоотой зардал.

2.5.8. Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд материал нийтлүүлэх зардал

2.5.9. Бусад зардлын дүн

- банкны үйлчилгээний хураамж;
- Сонгуулийн зардалд хамаарахгүй бусад зардал.

2.6. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны нийт зарлагын гүйлгээг **Маягт 9-д** гүйлгээ тус бүрээр оруулах бөгөөд зарлагын гүйлгээний дүнг энэ заавар, аргачлалын 2.5-д заасны дагуу ангилал тус бүрд харгалзуулан хуваарилна. Ингэхдээ нэг гүйлгээний дүн 1-ээс дээш зардлын ангилалд хамаарч байгаа нь анхан шатны баримтаар нотлогдож байвал тохирох зардлын ангилалд салгаж оруулна.

2.7. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансаар хийсэн зарлагын гүйлгээг бүртгэж, тайлагнахдаа Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-д заасан зардлын ангилалтай уялдуулна.

Гурав. Сонгуулийн зардлын тайлан бэлтгэх

Тайлан бэлтгэх дараалал

3.1. Сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтаар энэ заавар,

аргачлалын 3.7-д үзүүлсэн дарааллын дагуу бэлтгэж, баталгаажуулна.

Батлагдсан маягтын уялдаа, харилцан хамаарал

3.2. Нам, эвсэл, нэр дэвшигчид батлагдсан маягтуудаас өөрт хамаарах маягтуудыг сонгож, иж бүрэн тайлагнана. Маягтад нам, эвсэл, нэр дэвшигч тус бүрд хамаарах маягтыг тодорхойлсон болно.

Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах, хүргүүлэх

3.3. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангийн хураангуй болон бусад холбогдох маягтыг бэлтгэж, баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэл, тайлагнал хариуцсан ажилтан батлагдсан маягтын “Тайлан бэлтгэсэн” хэсэгт, нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээд, нэр дэвшигч “Тайлан хянасан” хэсэгт тус тус овог нэр, албан тушаалаа бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг энэхүү заавар, аргачлал болон батлагдсан маягтын дагуу бэлтгэж, “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 17, 18 дугаар зүйлд заасан хугацаанд тайлагнана.


3.5. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ батлагдсан маягтаас нам, эвсэл, нэр дэвшигч өөрт хамаарах маягтуудыг иж бүрэн бөглөж ирүүлэх бөгөөд тухайн маягтад оруулах мэдээлэл байхгүй байсан ч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтаар гаргаж Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ дараах байдлаар гаргаж ирүүлнэ. Үүнд:

№	Үзүүлэлт	Маягт бэлтгэж, ирүүлэх эсэх					
		Явцын тайлан			Эцсийн тайлан		
		Нам	Эвсэл	Нэр дэвшигч	Нам	Эвсэл	Нэр дэвшигч
1	Маягт 1-1	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
2	Маягт 1-2	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй
3	Маягт 1-3	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
4	Маягт 2	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
5	Маягт 3	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
6	Маягт 4	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм
7	Маягт 5	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
8	Маягт 6	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
9	Маягт 7	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
10	Маягт 8	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм

11	Сонгуулийн зардлын дансны банкны хуулга	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
12	Маягт 9	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
13	Хараат бус аудитын дүгнэлт	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
14	Бусад нэмэлт тайлбар тодруулга	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм

3.6. Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцогч нам, эсвэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан, тодруулга, тэдгээрийг дэмжих нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон холбогдох бусад материалыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны өдрийн А/222 дугаар тушаалын “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасан шаардлагын дагуу архивлана.



НАМЫН СОНГУУЛЫН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр
Тайлангийн төрөл: (доорх төрлөөс сонгож "✓" тэмдэглэлээ хийх)
Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан
Сонгуулийн дараа эцсийн тайлан

НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Намын нэр: _____		
Регистрийн дугаар: _____		
Нэр дэвшүүлсэн хүний тоо: _____		
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр: _____		
Дансны дугаар: _____		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо: _____		
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо: _____		
Эхний үлдэгдэл: _____		
Аймаг, нийслэл, сум, дүүрэгт зардлын данстай эсэх: _____		
Хэрэв тийм бол: _____		
Орон нутгийн салбарын нийт дансны тоо: _____		
Нийт орлого: _____ төгрөг		
Нийт зарлага: _____ төгрөг		
ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Тоо	Дүн /төгрөгөөр/
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Намын өөрийн хөрөнгө		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан хандив		
6.2 улсын орлого болгосон хандив		
(Анхаарах. Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

_____ / Албан тушаал /

_____ / гарын үсэг, нэр /

ТАЙЛАН ХЯНАСАН:

_____ / Албан тушаал /

_____ / гарын үсэг, нэр /

ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл: (доорх төрлөөс сонгож " " тэмдэглэлээ хийх)

Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан

Сонгуулийн дараа эцсийн тайлан

НЭГ. ЭВСЛИЙН ЕРӨНХИЙ мэдээлэл		
Эвслийн нэр:	_____	
Эвсэлд нэгдсэн намын тоо:	_____	
Нэр дэвшүүлсэн хүний тоо:	_____	
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:	_____	
Дансны дугаар:	_____	
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Эхний үлдэгдэл:	_____	
ГУРАВ. ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө		
Нам 1 /нэр/		
Нам 2 /нэр/		
Нам 3 /нэр/		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан дүн		
6.2 улсын орлого болгосон		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

.....
/ Албан тушаал //...../
/гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

.....
/ Албан тушаал //...../
/гарын үсэг, нэр/

НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Тайлан ирүүлсэн огноо: ... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл: (доорх төрлөөс сонгож " " тэмдэглэлээ хийх)

Сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнөх явцын тайлан

Сонгуулийн дараа эцсийн тайлан

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ мэдээлэл		
Ургийн овог:		
Эцэг /эхАийн нэр:		
Өөрийн нэр:		
Регистрийн дугаар:		
ХОЁР. ДАНСНЫ мэдээлэл		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:		
Дансны дугаар:		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... Оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... Оны ...-р сарын ...-ны өдөр	
Эхний үлдэгдэл:		
ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Нам/эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө		
1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		
1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		
1.3.1 Мөнгөн хандив		
1.3.2 Мөнгөн бус хандив		
1.4 Иргэний өгсөн нийт хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.7 цахим орчин ашиглах зардал		
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал		
2.2 Бусад зардлын дүн		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан дүн		
6.2 улсын орлого болгосон		
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн /төгрөг/	Огноо	Эх үүсвэр
1.				
2.				
3.				
Нийт дүн				

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

.....
/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

.....
/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Иргэний бүртгэлийн болон байгууллагын регистрийн дугаар			
1.	Иргэн				
2.					
3.					
		Дүн			
1.	Хуулийн этгээд				
2.					
3.					
		Дүн			
	Нийт дүн				

"Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ"

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

..... /...../

/ Албан тушаал / /гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

..... /...../

/ Албан тушаал / /гарын үсэг, нэр/

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Маягт-4

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	Эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Иргэний бүртгэлийн болон байгууллагын регистрийн дугаар					
1.	Иргэн						
2.							
3.							
	Дүн						
1.	Хуулийн этгээд						
2.							
3.							
	Дүн						
	Нийт дүн						

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

..... /...../
/ Албан тушаал / /гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

..... /...../
/ Албан тушаал / /гарын үсэг, нэр/

Эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн

Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:

Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.

Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Иргэний бүртгэлийн болон байгууллагын регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ /тегрөгөөр/	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1.						
2.						
3.						
Нийт дүн						

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

.....
/ Албан тушаал /

...../
/гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

.....
/ Албан тушаал /

...../
/гарын үсэг, нэр/

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН ОРЛОГО БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Иргэний бүртгэлийн болон байгууллагын регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Нийт хандивын хэмжээ /тегрөгөөр/	Шилжүүлгийн мэдээлэл			Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар
				Буцаасан	Улсын орлого болгосон	Огноо	
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Тайлбар: Шилжүүлгийн мэдээлэл хэсгийн буцаасан болон улсын орлого болгосон баганад мөнгөн дүнг тусгана.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

..... /
/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН:

..... /
/ Албан тушаал /

СОНГУУЛИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨГЛӨГИЙН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр _____

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн /төгрөгөөр/	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Иргэний бүртгэлийн болон байгууллагын регистрийн дугаар		
1.					
2.					
3.					

Нийт дүн

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

.....
/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

ТАЙЛАН ХЯНАСАН:

.....
/ Албан тушаал /

/...../
/гарын үсэг, нэр/

